

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэлх төмөр замын чангалагч системийг (fastening systems) нийлүүлэх компаниар Германы "Vossloh" сонгогджээ. Энэхүү төмөр замын бүтээн байгуулалтыг хариуцаж буй Өмнөд Солонгосын "Samsung C & T Engineering Construction Mongolia" компани "Vossloh"-ийн системийг сонгон гэрээ хийсэн байна.
- Монголын хамгийн том нүүрсний ордыг эзэмшигч "Эрдэнэс Тавантолгой" компани нүүрсний уурхайн метан хийг ашиглах төсөл хэрэгжүүлэхээр болсон. Энэхүү төслийг Солонгосын "Korea Gas Corporation" болон Монголын ерөмдлөгийн "Элгэн" компанитай хамтран хэрэгжүүлэх юм байна.
- Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлийн хөтөлбөрийн эхний үе шатыг 2013 онд батлан, хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Эхний үе шатны техникийн шинэчлэлийн үр дүнд Улаанбаатар төмөр замын нэвтрүүлэх техникийн хүчин чадал 70 гаруй хувиар нэмэгдэж, жилдээ 35 сая тонн ачаа тээвэрлэх боломжтой болох юм.
- Засгийн газраас зарласан экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрийн төслүүдийн талаар эдийн засгийн яамнаас мэдээлэл хийлээ. 888 төслийн 131 нь экспортыг дэмжих бөгөөд 1,036 тэрбум төгрөгийн зээл, 757 нь импортыг орлох бөгөөд 3,150 тэрбум төгрөгийн зээл хүсчээ. Нийт төсөл хэрэгжвэл 39 мянган ажлын байр шинээр бий болж, дунджаар 55 сарын дараа өртгөө эргүүлэн нөхөх ажээ.
- ОХУ дэлхийн газрын тосны магнат боловч Европ, АНУ-ын зах зээлийн эрэлт буурахын хэрээр Ази, тэр дундаа Хятадын зах зээлд газрын тос ахиу нийлүүлэхийг эрэлхийлж байна. Гэхдээ Хятадын газрын тосны бүтээгдэхүүний эрэлт сүүлийн 20 жилийн хугацаан дахь хамгийн доогуур хэмжээнд өсч буй юм.

ПРОФЕСИ СОАЛ КОМПАНИЙН УЛААН-ОВОО, ЧАНДГАНА ТӨСӨЛ УРАГШИЛЖ БАЙНА

Монголын эрчим хүчний нүүрсний салбарт томоохон тоглогч болж буй Професи компани энэ сарын эхээр Сэлэнгэ аймагт орших Улаан-Овоо төслийнхөө 2013 оны нүүрсний борлуулалтын тайланг мэдээллээ. Уг төслийг тус компани 2012 оны 7-р сард түр хугацаагаар хааснаас хойш жил хагасын дараа буюу өнгөрсөн оны арваннэгдүгээр сард нээж, оны сүүл гэхэд нийт 69,2 мянган тонн нүүрсийг борлуулжээ. Тус компанийн нүүрсний илчлэг нь 5300 ккал/кг, хүхрийн агуулга 0.5 хувь, үнслэг 5 хувьтай байдаг байна. Чанарун хувьд сайн байгаа учир эхний 8 жилд нүүрсээ угаах шаардлагагүй болохыг Професи онцолжээ.

Тус компани одоогоор нүүрсээ дотоодын үйлдвэр, станцаас гадна Сүхбаатар хилийн боомтоор дамжуулан Орос руу худалдаалж буй юм. Мөн Зэлтэрийн боомт руу нүүрсээ авто замаар тээвэрлэж экспортлохоор зорьж байна. Үүний тулд тус компани уурхайгаас Зэлтэрийн боомт хүртэлх замыг сайжруулах ажлын техник, эдийн засгийн судалгаа хийж байна. Судалгаа ирэх 5-р сард дуусна.

Нүүрсээ Сүхбаатар хүргэхэд 120 км. харин Зэлтэрийн боомт руу аваачихад 17 км зам туулах учир тээврийн зардлыг ихээхэн хэмнэх боломж бий ажээ.

Тус компани Монгол дахь бас нэгэн гол төсөл болох Чандгана 600 МВт-ын цахилгаан станцын төслөө Монголын Засгийн газарт өнгөрсөн долдугаар сард өргөн бариад байсан юм. Энэ дагуу өнгөрсөн нэгдүгээр сард Засгийн газар Чандганыг Концессийн төслөөр баталжээ.

Професи -ийн мэдээлж буйгаар уг төсөлд татварын таатай нөхцөл болон төрийн татаас ногдож магадгүй байгаа ажээ.



ЗАНАДУ, МОНГОЛ МЕТАЛС ХАРМАГТАЙ ТӨСЛИЙГ ХУДАЛДАЖ АВНА

Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Занаду Майнз" болон Монгол дахь хамтрагч "Монгол Металс" компани Хармагтай зэс-алтны хайгуулийн төслийн 90 хувийг худалдан авахаар болсноо энэ сарын эхээр мэдээлэв. Энэ хүрээнд "Монгол Металс" компани "Turquoise Hill Resources" компанид эхний ээлжинд 4 сая доллар төлөх бөгөөд үлдсэн 10 сая долларыг 18 сарын хугацаанд олгохоор гэрээнд тусгажээ. Одоогоор "Монгол Металс" төслийг эзэмшилдээ авч, хайгуулийн ажлыг эхлүүлэхэд зориулж нийт 8 сая долларын хөрөнгийг босгоод буй ажээ. Үүний тал хэсгийг "Занаду Майнз" нөгөө хэсгийг нь "Noble" группээс 3 жилийн хугацаатай зээл хэлбэрээр олгох ажээ. Хармагтай төсөл нь Өмнөговь аймагт оршиг бөгөөд Оюу Толгойгоос хойд зугт 120 км, Цагаан суваргын ордоос баруун тийш 170 км-т оршдог байна. Уг төслийн хайгуулын лиценз нь ойролцоогоор 66 ам км табайг хамардаг ажээ. Хайгуулын ажлаар 0.25-0.30 хувийн зэс, 0.25-0.30 гр/тн алтны агуулга бүхий 250-400 сая тонн хүдрийн нөөц илрүүлнэ гэж зорьж байгаа юм. Одоогоор хэд хэдэн хэсэгт хийсэн өрөмдлөгийн дээжийг шинжилж үзэхэд агуулга маш өндөр буюу 0.36-0.75 хувийн зэс, 0.22-2.48 гр/тн алтны агууламжтай гэж гарчээ. Хармагтай зэс-алтны төслийг хэрэгжүүлсэнээр 30 хувийн агууламжтай гэж гарчээ. Хармагтай зэс-алтны төслийг хэрэгжүүлснээр 30 хувийн агууламжтай баяжмал гарган авсан тохиолдолд борлуулалтыг "Noble" групп хариуцах юм.

BHP BILLITON LIMITED КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ САЙН БАЙНА

Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй ашигт малтмалын хайгуулын ажил, нүүрс, төмрийн хүдэр, алт, зэс, манганы хайгуулын болон олборлолтын зэрэг олон салбарт үйл ажиллагаа эрхэлдэг BHP Billiton компани одоогоор явуулж буй 10 үйл ажиллагааны болон 3 төрлийн бараа бүтээгдэхүүн тэр дундаа төмрийн хүдрийн хайгуул, олборлолтын тайлан шинжилгээний талаар мэдээллээ.

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны хүчин чадлын гүйцэтгэл сайн байсан нь дараагийн 2 жилийн туршид буюу 2015 оны санхүүгийн жилийг дуустал бараа бүтээгдэхүүний үйдвэрлэл 16% өснө хэмээн хүлээж байсан хүлээлтийг давуулан зөвхөн эхний хагас жилд бараа бүтээгдэхүүн 10% өсөхөд нөлөөлсөн хэмээн тус компанийн гүйцэтгэх захирал Андрою Маккензи хэллээ.

Ялангуяа төмрийн хүдэр болон металлургийн нүүрсний ажил маш сайн явагдсан ба бүтэн жилийнхээ төлөвлөгөөнд хүрсэн.

Төмрийн хүдрийн үйлдвэрлэл энэ өнгөрсөн 6 сарийн туршид 97.8 сая тоннд хүрч өмнөх жилийнхтэй харьцуулбал 19%-иар өссөн бол металлургийн нүүрсний олборлолт хагас жилдээ 22%-иар өсч хамгийн дээд хэмжээндээ буюу 22,2 сая тоннд хүрчээ. Газрын тосны шингэн үйлдвэрлэл өмнөх жилтэй харьцуулахад 9 %-иар өссөн хэдий ч нийт төлөвлөсөн хэмжээнээс 1%-иар бага байгаа юм. Зэсийн баяжмал 6%, цинк үйлдвэрлэл 18%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.



THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER
PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT CORPORATION IN MONGOLIA.

MICC хөрөнгө оруулалтын корпорацийн тухай

MICC нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа,
судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг

MICC ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин
танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх
боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

Эрхлэгч: Э. Оюу.

2014/03/21

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж, MSCI Barra,
OECD.